



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 235

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монгол тамга" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 33,000,000.00 (гучин гурван сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий Тоёота прадо маркийн, 12-66 УНТ улсын дугаар, VZJ1200003326 арлын дугаартай тээврийн хэрэгслийн ашиглах хугацааг 2 жилээр сунгаж, нийт үнийг 8,000,000.00 (найман сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож "Замын-Үүдийн дулааны станц" төрийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Монгол тамга" төрийн өмчит үйлдвэрийн газрын татан буулгах комиссын дарга бөгөөд Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын газрын дарга Ц.Баяр-Эрдэнэ, "Замын-Үүдийн дулааны станц" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал О.Төмөрхуяг нарт дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Тээврийн хэрэгслийг татвар төлөгчийн бүртгэл, улсын бүртгэлээс шилжүүлж арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх;

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001136

14-r huraldaan.docx